

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГТ
ХАМААРАХ ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024.12.25

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшнийг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэн, тухайн үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг хангахад чиглүүлэн, хөтөлбөрийн арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын шалгуурыг үндэс болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Ашигт малтмал, газрын тосны газраас 4 зорилтын 22 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөгдсөн байна. Тус газарт хэрэгжсэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилт нь 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 2 /100 хувь/, тодорхой үр дүнд хүрсэн 11 /70-99 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 1 /31-69 хувь/, үр дүнгүй 0 /0-30 хувь/ гэж үнэлэгдлээ.

Энэхүү хөтөлбөрийн 4.2.12-д “Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь” гэж, 4.2.15-д “Газрын тос дамжуулах хоолой барих төсөл Дорноговь” гэж, 4.2.16-д “Үндэсний алт цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл Улаанбаатар”-д гэж, 4.6.1-д “Хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна”-д гэж, 4.6.2-д “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах”-д гэж, 4.6.3-д “Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрээс катодын зэс үйлдвэрлэх төсөл” гэж, 4.2.6-д “Эрдэнэт үйлдвэрт үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах төсөл” гэж, 4.2.8-д “Рашаант дахь улсын нөөцийн агуулах төсөл” гэж, 7.3.4-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах

зориулалттай агуулахын цогцолбор байгуулна” гэж тус тус заасан арга хэмжээ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны чиг үүрэгт хамаарах тул үнэлгээ хийгээгүй болно.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт-1

д/д	Арга хэмжээний тоо	Үнэлгээ						Үнэлгээ хийгээгүй	Хэрэгжилт
		100%	90%	70%	50%	30%	0%		
1	22	2	3	8	1	-	-	8	81

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт 2024 оны жилийн эцэст хэрэгжсэн “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийн үнэлгээг дунджаар 81 хувиар үнэлэв.

Тайлант хугацаанд “Хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлээр доройтсон газрыг 22.9 хувиас нэмэгдүүлэхгүй тогтоон барьж, уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн 8000 га талбайд нөхөн сэргээлт хийнэ” гэсэн арга хэмжээний зорилтот түвшнийг “2024 оны ашиглалтын үйл ажиллагааны албажсан 366 төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 937.0 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 969.6 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 118,414.9 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2024 онд 4,231.8 га талбайд 18.2 сая мод тарихаар тусгуулан ажилласан байна.

“Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцүүлэн дотоодоос хангах хувь” гэсэн арга хэмжээний зорилтот түвшнийг “2025 онд 80 хувь” гэж төлөвлөсөн. Тус арга хэмжээ “2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар 2.5 сая тонн шатахуун импортолсны 14.3 хувийг евро 5 стандартын шатахуун эзэлж, Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад /Евро-5/ ангиллын шатахууны нийт импорт 43 хувиар өссөн дүнтэй байна” гэж тайлагнасан нь тодорхой үр дүн гарч эхэлж байна.

“Тавантолгойн нүүрсний бүлэг ордод технологийн шинэчлэл хийж, олборлолтыг төслийн хүчин чадалд хүргэх, нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах төсөл” гэсэн арга хэмжээний зорилтот түвшнийг “Нүүрс, хөрс тээврийн конвейрын хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 50 хувьд хүрнэ” гэж төлөвлөсөн байна. Тус арга хэмжээг “2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалын дагуу томилогдсон “Таван Толгой” ХК-ийн нүүрс ачиж, буулгах ложистик төвийн төслийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комисст 2024 оны 09 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд УУХ-ийн дарга Т.Зууннаст, мэргэжилтэн Д.Цолмонтуяа нар ажиллаж үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, холбогдох дүгнэлтийг гаргаж, ашиглалтад зөвлөмж хүлээж авсан байна.

“Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх” гэсэн арга хэмжээний зорилтот түвшнийг “Асгатын мөнгөний ордыг нөөцийг ОУ-ын “Жорк” ангилалд нийцүүлэх ажлыг эхлүүлсэн. Хайгуулын ажилд шаардлагатай зам засах, хэвтээ ам нээх, гадаргуугийн бүрэн зураглал буюу топо геодези, хэвтээ малталтын 3-н хэмжээст зураглал, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээний ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Санхүүжилтийг “Эрдэнэс Монгол” нэгдэл өөрийн хөрөнгөөр бүрэн

шийдвэрлэв.” гэж тайлагнасан нь тус арга хэмжээний үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

“Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах төсөл” гэсэн арга хэмжээний зорилтот түвшнийг “Далд уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ” гэж төлөвлөсөн байна. Тус арга хэмжээг “Монголросцветмет ТӨҮГ-ийн MV-011722 тусгай зөвшөөрөлтэй Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайн 2023 оны уулын ажлын тайлан 2024 оны 01 дүгээр сарын 22-ний өдөр, 2024 оны уулын ажлын төлөвлөгөөг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хянаж, холбогдох засвар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тайланг хүлээн авсан” гэж тайлагнасан нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй буюу арга хэмжээ удаашралтай, удирдлага зохион байгуулалт хангалтгүй байна.

Дөрөв. Дүгнэлт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт”-д Ашигт малтмал, газрын тосны газраас хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар 81 хувьтай үнэлэв.

Хоёр. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн арга хэмжээнүүдээс 50 хувиар үнэлэгдсэн “Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах төсөл” гэж төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Гурав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны чиг үүрэг тул хэрэгжилт гаргаагүй 8 арга хэмжээ байна.

Тав. Зөвлөмж

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд тусгагдсан арга хэмжээнүүдийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн арга хэмжээнүүдээс 50 хувиар үнэлэгдсэн “Цагаансуваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах төсөл” гэж төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тул төсөл хөтөлбөрүүдийг эрчимжүүлж, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах.

Хоёр. Ашигт малтмал, газрын тосны газрын нэгжийн дарга нар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэлтсийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг сайжруулах;

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛСЭН МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2024 оны жилийн эцсийн байдлаар/**

2024.12.25

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлж, тухайн бодлогын зорилго, зорилтуудыг хангах чиглэлд арга хэмжээг цаг хугацаанд нь хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж, дүгнэх шалгуурыг үндэс болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Ашигт малтмал, газрын тосны газраас 4 зорилтын 17 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн байна. Тус газарт хэрэгжсэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт”-ийн хэрэгжилт нь 2024 оны жилийн эцсийн байдлаар удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан 3 /100 хувь/, тодорхой үр дүнд хүрсэн 7 /70-99 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 1 /31-69 хувь/, үр дүнгүй 2 /0-30 хувь/ гэж үнэлэгдлээ.

Энэхүү хөтөлбөрийн 3.2.6.2-д “Уул уурхайн салбарын судалгаа шинжилгээний байгууллагыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах асуудлын хүрээнд яамны харьяанд аж ахуйн тооцоот газрыг бий болгоно” гэж, “3.2.7.7-д “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулна” гэж, 3.2.8.2-д “ Дамжуулах хоолой барих төслийн ТЭЗҮ, инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлах, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулна” гэж, 3.2.8.3-д “Газрын тосны төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани байгуулах эрх зүйн орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, Газрын тосны судалгаа, шинжилгээ, хайгуул, ашиглалт, боловсруулалт, хангамжийн цогц үйл ажиллагаа явуулах төрийн өмчит Үндэсний компани байгуулна” гэж тус тус заасан арга хэмжээ нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны чиг үүрэгт хамаарах тул АМГТГ-аас үнэлгээ хийгээгүй болно.

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт-1

Д/д	Арга хэмжээний тоо	Үнэлгээ						Үнэлгээ хийгээгүй	Хэрэгжилт
		100%	90%	70%	50%	30%	0%		
1	17	4	1	6	2	-	1	4	78.1

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт 2024 онд хэрэгжсэн “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн үнэлгээг дунджаар **78.1** хувиар үнэлэв.

“Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт хамаарах арга хэмжээний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 67.7 хувиар үнэлэгдсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 10.4 хувиар үнэлгээ өссөн байна.

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.6.3-д “Орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулна” гэсэн арга хэмжээний хэрэгжилт “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 295 дугаар тогтоолоор Ашигт малтмал, газрын тосны газрын орон тоог 150 байсныг 185 болгон өөрчилж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/269 дугаар тушаалаар батлуулсан. Орон нутаг дахь төлөөлөл хариуцсан газрыг 35 албан хаагчтайгаар Сэлэнгэ, Ховд, Өмнөговь, Дорнод, Дорноговь, Өвөрхангай аймагт нэгж байгуулан ажиллаж байна” гэж тайлагнасан нь зорилтдоо бүрэн хүрсэн байна.

Энэхүү хөтөлбөрийн 3.2.6.4-д “Шинэ бүтээн байгуулалтын ажилд зайлшгүй шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг хамтын ажиллагааны хүрээнд холбогдох яам, байгууллагатай зохион байгуулна” гэсэн арга хэмжээний хэрэгжилт “Хүний нөөцийн судалгаа хийх, санал боловсруулах ажлын хүрээнд орон нутагт эрдэс баялгийн асуудал хариуцсан нэгж байгуулахтай холбоотой ажиллах хүчний судалгаа хийж, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан төрийн албаны зөвлөлд хүргүүлж батлуулсан. 2024 оны сургалтын төлөвлөгөөг Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.01-ний өдрийн А/50 дугаар тушаалаар батлуулсан. 2024 оны 12 дугаар сарын байдлаар уул уурхай, газрын тосны чиглэлээр Канад улсад 2, Австрали улсад 3, АНУ 1 оюутан Засгийн газрын баталсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын ажлыг гүйцэтгэж байгаа гадаад, дотоодын компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр АМГТГ-тай сургалтын урт хугацааны гэрээ байгуулан суралцаж байна. Тус гэрээгээр 2020 онд 13, 2021 онд 5, 2022 онд 2, 2023 онд 4, 2024 онд 3 оюутан тус тус төгсөн уул уурхай, газрын тосны чиглэлээр ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолоор “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам” батлагдсанаар гадаадад суралцах оюутны сонгон шалгаруулалтыг Боловсролын яамнаас зохион байгуулахаар болсон” гэж тайлагнасан нь зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан байна.

Мөн хөтөлбөрийн 3.2.8.4-д “Газрын тосны хайгуулын талбайд шинээр газрын тосны орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулна” гэсэн арга хэмжээг “Бүтээгдэхүүн хуваах гэрээт Галба-11 талбайн “Өлгий” ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж зохиогчийн хувилбараар хүлээн авсан бөгөөд бусад хайгуулын ажлаар шинээр орд нээх, нөөцийг өсгөх ажил үргэлжлэн явагдаж байна.” гэж тайлагнасан нь боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн байна.

Хөтөлбөрийн 3.2.8.3-д “Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна” гэсэн арга хэмжээг “Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 2.3 сая тонн шатахуун импортлон, хэрэглэснээс Евро-5 стандартын шатахуун 326.6 мянган тонн буюу нийт шатахууны 14 хувийг эзэлж байна.

Манай гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр 2024 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг зорилтот түвшинд хүргэж нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байсан. Тухайлбал, дайны нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын дотоод зах зээл дээр К-5 /Евро-5/ стандартын шатахууны эрэлт нэмэгдэж, экспортын хязгаарлалт хийсэн, мөн БНХАУ-ын төмөр замаас Монгол улс руу шатахуун тээвэрлэх вагоны зөвшөөрөл энэ оны 3 дугаар сараас хойш олгоогүй зэрэг шалтгаанаар нийлүүлэгч талаас К-5 /Евро-5/ стандартын шатахууныг захиалгын дагуу нийлүүлээгүй болно” гэж тайлагнасан нь өөрөөр шалтгаалах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Хөтөлбөрийн 3.2.8.3-д “Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээг “Төсөл хэрэгжүүлэгч “Трансгейт интернэшнл” ХХК нь 2021 оноос Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авсан. Мөн төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэж БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Гадаад нөхцөл байдалтай холбоотойгоор төсөл хэрэгжүүлэгч компани нь ТЭЗҮ-д шаардлагатай зарим тодотголыг хийсэн. Тухайн үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжид газрын тосны боловсруулах үйлдвэрийн технологийн байгууламжийн талаарх мэдээлэл, зөвлөмж боловсруулж цахим хаягаар хүргүүлсэн. Төслийг хэрэгжүүлэгч компаниас Ховд аймагт хэрэгжүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй тул одоогийн байдлаар үйлдвэрийн төсөл түр зогсонги байгаа талаар 2023.12.04-ны өдрийн А/38 дугаартай албан бичиг ирүүлсэн” гэж тайлагнасан нь тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил хийгээгүй байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 2024 оны байдлаар **78.1** хувьтай үнэлэв.

Хоёр. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй

үнэлэгдсэн. Энэ нь “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.6-д “Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хоёр удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол удааширсан, гурван удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол тасарсанд тооцно” гэж заасан байна.

Гурав. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны чиг үүрэгт хамаарах хэрэгжилт гаргаагүй 4 арга хэмжээ байна.

Тав. Зөвлөмж

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.8.3-д “Баруун бүсийн шатахууны хэрэглээний тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлнэ” гэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй байх тул уг хөтөлбөрөөс хасуулах саналтай байна;

Хоёр. Ашигт малтмал, газрын тосны газрын нэгжийн дарга нар бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг 2024 оны байгууллагын болон бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг агентлагийн нэгийн дарга нарт тус тус зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**
/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024.12.25
хот

Улаанбаатар

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Ашигт малтмал, газрын тосны газрын хариуцсан хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар явцын үнэлгээ хийж, зорилт, арга хэмжээний хэрэгжилт төлөвлөсөн түвшинд хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгөн, удирдлагыг мэдээллээр хангахад оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлж, дүгнэх шалгуурыг үндэслэл болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс Ашигт малтмал, газрын тосны газраас 3 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөгдсөн бөгөөд хэрэгжилт нь 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар тодорхой үр дүнд хүрсэн 3 /70 хувь/ гэж үнэлэгдлээ.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хамаарах чиг үүрэг бүхий арга хэмжээнүүдийг хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулаагүй болно.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт №1

д/д	Арга хэмжээний нэр	Үнэлгээ						Хэрэгжилт
		100%	90%	70%	50%	30%	0%	
1	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, нэмэгдүүлэх			√				70%
2	Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах			√				70%
3	Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах			√				70%
Нийт үнэлгээ								70%

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газарт 2024 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжсэн “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн үнэлгээг дунджаар 70.0 хувиар үнэлэв.

Тайлант хугацаанд “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний 2.2.1.4. “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох үйл ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газрынхантай хамтран www.tender.gov.mn цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийлгүүлж, сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, үнэлгээ хийх үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, 2022.11.23-нд сонгон шалгаруулалтын талбайг олон нийтэд ил тод нээлттэй зарлаж эхэлсэн бөгөөд 2024 онд цахим системийн 2 дугаар хэсгийн хөгжүүлэлтийг улсын төсвийн хөрөнгөөс 19.8 сая төгрөгөөр санхүүжүүлэн 10 төрлийн үйлчилгээг нэмэлтээр цахимжуулахаар гүйцэтгэгч компанитай ажлыг гүйцэтгүүлж дууссан байна. 2024 онд 2 удаагийн нийт 50 талбай буюу 144,187 гектар талбайд сонгон шалгаруулалт зарлаж 63 тусгай зөвшөөрөл олгож улсын төсөвт 35,2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.” гэж тайлагнасан нь шалгуур үзүүлэлт, зорилтод түвшиндээ тодорхой үр дүн гарсан байна.

Хөтөлбөрийн 2.2.2.1. “Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах” гэсэн арга хэмжээний хүрээнд Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжилтийн мэдээлэл авахаар 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1/4814 тоот албан бичгийг “Эрдэнэс Цагаан суварга” ХХК-д хүргүүлсэн.

Төслийн бүтээн байгуулалт үргэлжилж байгаа ба гүйцэтгэлийн төлөв Зураг төсөл - 90%, Газар шороо - 90%, Барилга бүтэц - 90%, Металл хийц - 61%, Сэндвич хана - 36%, Цахилгаан угсралт - 25%, Шугам хоолой - 6%-тай үйл ажиллагаа явагдаж байгаа гэж тайлагнасан нь тодорхой үр дүн гарсан байна.

Тус хөтөлбөрийн 2.2.2.2. “Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах” гэсэн арга хэмжээний хүрээнд “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Асгатын мөнгөний ордтой холбоотой арга хэмжээний биелэлтийн тайланг ирүүлэх, яам, агентлагаар дамжуулан шийдвэрлүүлэх санал, хүсэлт ирүүлэх тухай 2024 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 11/3275 дугаар албан бичгийг “Эрдэнэс Монгол ХХК”-д хүргүүлсэн. Асгатын мөнгөний ордыг нөөцийг Олон улсын “Жорк” ангилалд нийцүүлэх ажлыг эхлүүлсэн. Хайгуулын ажилд шаардлагатай зам засах, хэвтээ ам нээх, гадаргуугийн бүрэн зураглал буюу топо геодези, хэвтээ малталтын гурван хэмжээст зураглал, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээний ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Санхүүжилтийг “Эрдэнэс Монгол” нэгдэл өөрийн хөрөнгөөр бүрэн шийдвэрлэсэн.

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2023 оны төсөвт Асгатын мөнгөний ордын ашиглах ордыг олборлох боломжийг судлах, олон улсын (JORC) стандартаар хайгуулын ажлыг хийх, бусад холбогдох үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 11,090,452,828 төгрөг тусгасан. Үүнд:

- Асгатын ордын уурхайн хэвтээ ам хүртэлх зам засах ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- Асгатын ордын уурхайн амнуудыг нээх ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан.
- Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын 3-н хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх ажилд гүйцэтгэгчээр

шалгарсан компанитай гэрээ байгуулсан” гэж тайлагнасан нь тодорхой үр дүн гарсан байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна.

Нэг. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, Ашигт малтмалын тухай хуульд Ашигт малтмал газрын, тосны газрын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажилласнаар “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2024 оны жилийн эцсийн байдлаар **70.0** хувьтай хэрэгжүүлж ажиллав.

Тав. Зөвлөмж

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг гаргаж байна.

Нэг. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаа, зорилтот түвшиндээ хүрч байгаа эсэхэд анхаарч, хяналт тавьж ажиллахыг Хайгуул ашиглалтын газрын дарга, Кадастрын хэлтсийн дарга нарт зөвлөмж болгож байна.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА**

/2024 оны жилийн эцсийн байдлаар/

2024.12.25
ХОТ

Улаанбаатар

Нэг. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 болон Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж боловсруулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.6.1, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.2.1, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журмын 4.7-д "Байгууллагын захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж байгууллагын гүйцэтгэлийн тайланг нэгтгэх бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ" гэж заасны дагуу байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримталж ажиллав.

Байгууллагын төлөвлөсөн үйл ажиллагааны 26 зорилт, 60 арга хэмжээний урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтот түвшинд хүрч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхойлж, үр дүнг сайжруулах дүгнэлт, зөвлөмж гарган хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн болно.

Ашигт малтмал, газрын тосны газар 2024 онд Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан, Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажилласан. Тус систем нь Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан журам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтаар баталсан загварын дагуу байгууллага, бүтцийн нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төлөвлөж, тайлагнахаар программчлагдсан.

Мөн Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу бүхэл болон задгай

үнэлгээгээр үнэлгээний дүнг тооцож, нэгтгэлийг автоматаар гүйцэтгэх боломжтойгоороо давуу талтай.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд оновчтой хуваарилан төлөвлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд төлөвлөлт, тайлагналтын шатанд алдаа гаргахгүй байх зорилгоор Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд “Байгууллага - Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа” цэсээр дамжуулан хянаж ажилласан. Ингэхдээ байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулж, нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах чиглэлд “Нэгж - албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа” цэсийг ажиллуулж дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг хийсэн.

Гурав. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Төсвийн шууд захирагч нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 26 зорилтын 60 арга хэмжээг агентлагийн 12 бүтцийн нэгжийн үндсэн чиг үүргийн дагуу хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан.

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Хүснэгт-1

№	Зорилтын нэр	Үүнээс							Дундаж
		100%	90%	70%	50%	30%	0%	90>...>70	
1	Нэг. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	4	1	3	0	0	0	0	87.5%
2	Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	19	13	2	1	0	0	0	93.14%
3	Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	11	6	0	0	0	0	0	96.47%
	НИЙТ	34	20	5	1	0	0	0	93.33%

*Нийт үнэлгээг арга хэмжээний дунджаар тооцсон болно.

Дөрөв. ДҮГНЭЛТ

4.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн баталсан Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлангийн биелэлт нь жилийн эцсийн байдлаар **93.33** хувиар үнэлэгдэж, өмнөх жилийн гүйцэтгэлийн үнэлгээнээс 2.27 хувиар өссөн байна.

4.2. Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээнд хамрагдсан 26 зорилт, 60 арга хэмжээнээс 100 хувийн биелэлттэй 34, 90 хувийн биелэлттэй 20, 70 хувийн биелэлттэй 5, 50 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна.

4.3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээг агентлагийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд оновчтой хуваарилан төлөвлөх, хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлд төлөвлөлт, тайлагналтын шатанд алдаа гаргахгүй байх зорилгоор Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санд “Байгууллага - Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний уялдаа” цэсээр дамжуулан хянаж, дээрээс доош чиглэсэн төлөвлөлтийг хийсэн нь төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний шатанд гарах алдааг багасгаж, гүйцэтгэлийн дүн өмнөх оноос өсөхөд нөлөөлсөн байна.

Тав. ЗӨВЛӨМЖ

5.1. Ашигт малтмал, газрын тосны газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд газар, хэлтсүүдийн хариуцан хэрэгжүүлэхээр тусгах зорилт, арга хэмжээг төлөвлөхдөө бүтцийн нэгжийн хөгжлийн бодлогын баримт бичиг, хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, АМГТГ-ын стратеги төлөвлөгөө, стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй уялдуулан төлөвлөхийг бүх нэгжийн дарга нарт;

5.2. АМГТГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг зохион байгуулалтын бүтцийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг бүх нэгжийн дарга нарт;

5.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний суурь түвшин, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэрэгжүүлэх хугацааг холбогдох журам, аргачлалд заасан төлөвлөлтийн шаардлагад нийцүүлж боловсруулахыг нэгжийн дарга, албан хаагчдад;

5.4. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн үнэлгээгээр хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй арга хэмжээг байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг холбогдох нэгжийн дарга нарт, хэрэгжилтийг хангуулах чиглэлд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

5.5. Холбогдох нэгжүүд хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг тайлант хугацааны гүйцэтгэлээр бий болсон явцын ахиц өөрчлөлтийн талаар тайландаа бүрэн тусгах чиглэлд анхаарч ажиллахыг нэгжийн дарга, албан хаагчдад тус тус зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР